



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 52

Мөрөн

**“Хөвсгөлийн эргэлтийн эмийн сан”
ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, 77 дугаар хуулийн 77.4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөлийн эргэлтийн эмийн сан” ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийг төлөөлж оролцох гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

1. Б.Батчимэг- аймгийн Эрүүл мэндийн газрын удирдлагын хэлтсийн дарга
2. Ч.Лхагвамядаг- аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
3. Б.Билэгт-Отгон-аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан
4. Н.Одбаатар- аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан
5. Л.Юмжирдулам-аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

2. “Хөвсгөлийн эргэлтийн эмийн сан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах хүмүүсийг томилсугай.

1. Ц.Буяннэмэх – Далайн элбэрэл ӨЭМТ-ийн дарга
2. Ж.Лхагвасүрэн – Мөрөн сумын иргэн
3. Э.Инжир-Нэгдсэн Эмнэлэгийн их эмч
4. Ц.Мөнхтуяа- Мөрөн сумын иргэн

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 оны 05 дугаар сард багтаан хуралдуулж, удирдамжийг батлуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 74 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

110150150

5. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР